



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/583

Булган сум

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны мн/243 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны мн/29 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын урьдчилсан үзлэгийг сумдад 2025 оны 10 дугаар сарын 02-11-ний хооронд, нэгдсэн үзлэгийг 10 дугаар сарын 15-ны өдөр Булган суманд төвлөрүүлэн зохион байгуулж Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Сэлэнгэ, Хангал сум, Хялганат тосгоныг хамруулсугай.

2.Цэрэг татлагын товчоог 1 дүгээр, эмч нарын комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар, цэрэг татлагын эрүүл мэндийн урьдчилсан үзлэг явуулах хуваарийг 3 дугаар, зарцуулах хөрөнгийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталж, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг хуваарийн дагуу явуулах, цэрэг татлагын ажлыг сайтар зохион байгуулахыг Цэрэг татлагын товчоо (Д.Эрдэнэбилэг), Цэргийн штаб (Дэд хурандаа Т.Нямхүү), эмч нарын комисс (Б.Шижирбаатар)-т тус тус хариуцуулсугай.

3.2025 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагад зарцуулах 15,287,000 (арван таван сая хоёр зуун наян долоон мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

4.Сумын Эрүүл мэндийн төв, цагдаагийн байгууллагатай хамтран мансууруулах бодисын хамааралтай, энэ төрлийн эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн түүхий эдийг хэрэглэдэг, мансуурах донтой иргэдийн судалгаа, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж өвчилж болзошгүй болон сүрьеэгийн ойрын хавьталтай цэргийн насны залуучуудын судалгааг тус тус гаргаж, цэрэг татлагаас өмнө сүрьеэгийн сорил тавих ажлыг зохион байгуулан ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Эмнэлгийн үзлэгт орох залуучуудын шинжилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 1, 6, 7 дугаар

6325010802

зүйлийг үндэслэн зохион байгуулахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга (П.Оюунцэцэг), Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Чулуунчимэг) нарт тус тус хариуцуулсугай.

6.Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллах, хугацаат цэргийн албанд татагдаж буй иргэнийг тээвэрлэх арга хэмжээг зохион байгуулахдаа хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөж, авто техникийн бүрэн бүтэн байдлыг сайтар хангах, хамрагдвал зохих хүмүүсийг бүрэн хамруулан аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хяналтын тоог биелүүлж, цэрэг татлагын ажлыг хугацаанд нь зохион байгуулж, дүнг 2025 оны 10 дугаар сарын 25-ны дотор илтгэхийг Цэрэг татлагын товчоо (Д.Эрдэнэбилэг), Цэргийн штаб (Дэд хурандаа Т.Нямхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.П.РЭВ-ОЧИР




Аймгийн Засаг даргын 2025 оны  
09 дүгээр сарын 19-ны өдрийн 7 дүгээр  
захирамжийн 1 дүгээр хавсралт



## 2025 ОНЫ ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧОО

Цэрэг татлагын товчооны дарга	Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Цэрэг татлагын товчооны орлогч дарга	Т.Нямхүү (Цэргийн штабын дарга Дэд хурандаа)
Нарийн бичгийн дарга	Н.Төмөр-Очир (Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер Дэд хурандаа)
Цэрэг татлагын товчооны Гишүүд:	Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн Хурандаа)
	Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, Дэд хурандаа)
	П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
	Б.Шижирбаатар (Нэгдсэн эмнэлгийн захирал)
	Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
	Ж.Ганболд (Сайхан сумын Засаг дарга)
	Б.Бямбажав (Баян-Агт сумын Засаг дарга)
	С.Батнасан (Аймгийн ЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)
	Б.Чулуунчимэг (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
	Б.Намнансүрэн (Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, бэлтгэл сургалтын офицер Дэд хурандаа)
	Ц.Цэрэнтогтох (Цэргийн штабын дайчилгааны офицер, Хошууч)

Аймгийн Засаг даргын 2025 оны  
09 дүгээр сарын 14-ны өдрийн 1/390т  
захиралжийн 2 дугаар хавсралт



Эмч нарын комиссын бүрэлдэхүүн

- |  |                             |
|--|-----------------------------|
| 1. Ерөнхий эмч (Нэгдсэн эмнэлгийн захирал) | Б.Шижирбаатар               |
| 2. Дотрын эмч                              | А.Наранхүү                  |
| 3. Мэс заслын эмч                          | М.Билгүүн                   |
| 4. Чих, хамар хоолойн эмч                  | Б.Сүхдорж                   |
| 5. Мэдрэлийн эмч                           | Д.Гүндэгмаа                 |
| 6. Сэтгэцийн эмч                           | Б.Мөнхтүвшин                |
| 7. Нүдний эмч (Амбулаторийн эрхлэгч)       | М.Давхарбаяр                |
| 8. Арьс өнгөний эмч                        | Ч.Амаржаргал                |
| 9. Сүрьеэгийн эмч                          | Г.Цэрэнлхам                 |
| 10. Шүдний эмч                             | Б.Бат-Ундраа                |
| 11. Дүрс оношилгооны эмч                   | Б.Бүрэндондов<br>М.Энхцэцэг |
| 12. Рентген техникч                        | Ж.Түвшинсанаа               |
| 13. Оношилгооны тасгийн лаборант           | Д.Ганганцэцэг               |

Аймгийн Засаг даргын 2023 оны  
09 дүгээр сарын 15-ны өдрийн 389 дот  
захирамжийн 3 дугаар хавсралт



СУМДАД ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГ  
ЯВУУЛАХ ХУВААРЬ

№	Сумын нэр	Урьдчилсан үзлэг явуулах хугацаа	Үзлэгт орох хүний тоо	Цэргийн жинхэнэ албанд татах хүний тоо
1	Сайхан	10-р сарын 02	168	23
2	Баян-Агт	10-р сарын 03	149	18
3	Хутаг-Өндөр	10-р сарын 04	167	25
4	Тэшиг	10-р сарын 05	128	16
5	Бугат	10-р сарын 07	93	10
6	Сэлэнгэ	10-р сарын 08	130	18
7	Хялганат	10-р сарын 09	91	15
8	Хангал	10-р сарын 10	42	8
9	Булган	10-р сарын 11	528	40
10	Аймгийн нэгдсэн үзлэг	10-р сарын 15		
11	Анги байгууллага руу үдэн гаргах	10-р сарын 16		
Бүгд			1496	173

Аймгийн Засаг даргын 2025 оны  
09 дүгээр сарын 7-ны өдрийн 4 дугаар тоот  
захирамжийн 4 дүгээр хавсралт



2025 ОНЫ ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГАД  
ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ /төг/	Тайлбар
1	Цэрэг татлагын товчоо, сумаас цэрэг хүргэж ирсэн хүмүүс, Цэргийн ангиас цэрэг хүргэж ирсэн офицерууд, ЦТБ дээр ажиллах хүмүүсийг хооллох, байрлуулах	9,825,000	65 хүн 1 өдөрт 35000 төг 3 өдөр хооллоно. Байр-20*3*50000=3000000
2	Цэргийн албанд татагдсан залуучуудыг цэргийн анги байгууллагад хүргэх замд 1 удаа хооллоход	1,530,000	153 хүн 1 удаа (1 хүн 10000 төгрөгөөр хооллоно)
3	Суманд цэрэг татлагын урьдчилсан үзлэг явуулах, УБ хотруу цэрэг хүргэж өгөх унааны зардал /шатахуун/	1,632,000	АИ-92 600л*2720
4	Суманд ажиллах эмч нарын томилолтын зардалд	1,350,000	5 эмч 9 хоног*30000
5	Бусад зардалд	950,000	Цэвэр ус, нойтон сальфетка, гар ариутгагч, маск гэх мэт
<b>Бүгд</b>			<b>15,287,000</b>